



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 4/0-7

Дэлгэрхаан сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
асуудал хариуцсан орон тооны бус ажилтан
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дах хэсгийг, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1 дүгээр зүйлийн 1.в дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан Б.Золжаргалыг 2025 оны 04 дүгээр сарын 01 өдрөөс эхлэн хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтанаар томилсугай.

2.Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлэх, үр дүнд хяналт тавьж ажиллахыг (Б.Золжаргал)-д даалгасугай.

3.Б.Золжаргалд ур чадварын нэмэгдэлийг үндсэн цалингийн 15%-иар тооцон олгохыг нягтлан бодогч (Г.Энхчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



О.БАТБАЯР